2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЖ ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

| № | Өгсөн зөвлөмж | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас | Жилийн эцэс | | |
| **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** | **7** | **8** | **9** |
| 1 | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үр дүнг хагас бүтэн жилээр тооцож, хэрэгжилтийн хувийг өмнөх оноос нэмэгдүүлэх | 1. Орон нутгийн төсөвт оруулах орлогын төлөвлөгөөний биелэлт (2024 онд 53,000,000 төгрөг) | Хэрэгжилтийн дундаж хувь | 100 | 50 | 100 | 1. Орон нутгийн өмчит 11 сум, 24 байгууллагын 130 иргэн, хуулийн этгээдтэй “Орон нутгийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ”-г байгуулан орлого төвлөрүүлэлтэд хяналт тавин ажиллаж байна. 2024 оны 11 сарын 07-ны өдрийн байдлаар түрээсийн орлогын дансанд 17.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. Мөн орон нутгийн өмчит 2 байгууллагын 2 ширхэг тээврийн хэрэгслийг акталж, сэлбэг хэрэгслээр ашиглах 9 байгууллагын 12 тээврийн хэрэгсэл, 7 барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдан борлуулж орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд 118.6 төгрөг, Орон сууц хувьчлалын орлогоос 21.1 сая төгрөг нийт 139,7 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна.<br>Үр дүн:<br>✓ 2023 оны Орлого 53,000,000 байсан бол 2024 оны 11 дүгээр сарын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байдлаар 139,7 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.<br>✓ Хэрэгжилтийн хувийг өмнөх оноос нэмэгдүүлсэн. | |
| | | 2. Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт | Хэрэгжилтийн дундаж хувь | 85 | 50 | 95 | 2.Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгөд хяналт шалгалт зохион байгуулж, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын удирдамж”-ын дагуу 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 15 сумын 100 байгууллага, аймгийн төвийн 23 байгууллагуудын өмч хөрөнгийн байдал, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдал, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч цаашид анхаарах зүйлс болон хэрэгжүүлэх арга хэмжээг зөвлөмж хэлбэрээр хүргүүлэн ажиллалаа.<br>Үр дүн:<br>✓ Байгууллагуудын зөрчил арилсан<br>✓ Өмч хамгааллын байнгын зөвлөлийн гишүүдийг идэвхжүүлэх сургалтад хамруулсан. | |
| 2 | Салбарын тоон үзүүлэлтийн судалгааг нарийвчлан гаргаж, бодлогын | Өмчийн холбогдолтой тоон үзүүлэлтийн судалгааг гаргах | Судалгааг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байх тоо | 0 | 1 | 1 | Орон нутгийн өмчийн салбарын тоон үзүүлэлтийн судалгааг дараах 5 төрлөөр гарган цахим хаягтаа байршуулан ажиллалаа.Үүнд<br>• 2020-2023 хүртэлх тээврийн хэрэгслийн судалгаа | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | баримт бичгийн төлөвлөлтийн суурь судалгаанд ашиглах мэдээллийн сан бүрдүүлэн, цахим хуудсанд байршуулах | | | | | | • 2020-2023 хүртэлх үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн судалгаа<br>• 2020-2023 хүртэлх дуудлагын худалдаа болон Хөрөнгө борлуулсны орлого<br>• 2024 оны Барилга байгууламж ашиглалтын зориулалтаар ангилсан судалгаа<br>• 2024 оны Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын төрлөөр график мэдээлэл боловсруулан гаргаж, байгууллагын цахим хуудас болон веб хуудаст байршуулан 829 хүний хандалт авч ажиллалаа.<br>Үр дүн:<br>✓ Өмнө жилүүдэд салбарын хэмжээнд нэгдсэн судалгааны бааз байгаагүй бөгөөд 2024 онд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэгдсэн судалгааг бий болгосон. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Цахим хуудасны орон нутгийн мэдээллийг өөрийн албан ёсны фэйсбүүк хуудсаараа дамжуулан нийтэд түгээх, фэйж хуудасны хандалтын тоог өмнөх оноос нэмэгдүүлэх | Цахим хуудсаар дамжуулан мэдээлэл түгээх | Дамжуулсан мэдээлийн тоо | 50 | 50 | 80 | 2024 01 дүгээр сарын 02-ны өдөр байгууллагын фейсбүүк хаягийг шинээр нээн хөгжүүлж, 11 дүгээр сарын байдлаар 5244 гишүүнтэй болсон байна. Мөн байгууллагын фейсбүүк хаягт байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 128 мэдээ мэдээллийг байршуулж, Аймгийн Засаг даргын Тамгын газрын 526, авлигатай тэмцэх газрын 166, бусад цахим хаягаас 50 мэдээллийг хуваалцаж, нийтдээ 870 мэдээ мэдээллийг олон нийтэд түгээн ажилласан байна. Мөн сүүлийн 90 хоногийн байдлаар фейсбүүк хуудасны хандалтын тоо 14,434 хүрсэн байна.<br>Үр дүн:<br>✓ Байгууллага өөрийн гэсэн фейсбүүк хаягтай болсон.<br>✓ Өөрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтмол иргэд, олон нийтэд мэдээлэлдэг болсон. | 100% |
| 4 | Байгууллагын цахим хуудаст мэдээллийг шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн байршуулж, ил тод байдлын үнэлгээг өмнөх оноос нэмэгдүүлэх | Ил тод байдлын үнэлгээг өмнөх оноос нэмэгдүүлэх | Хэрэгжилтийн хувь | 70,8 | 50 | 90 | Байгууллагын цахим хуудаст байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг шалгуур үзүүлэлтийн дагуу байршуулж, ил тод байдлын үнэлгээг хагас жилийн байдлаар 71,37% үнэлүүлж, өмнөх оноос 0.57%-аар нэмэгдүүлэн ажилласан. Жилийн эцсийн нээлттэй мэдээллийн ил тодын байдлын нэгдсэн системд оруулах шаардлагатай мэдээ мэдээллийг байгууллагын самбар болон цахим хуудаснуудад шалгуурын дагуу шинээр | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оруулж байгаа учир үнэлгээ хийгдээгүй байна.<br>Үр дүн:<br>✓ Хагас жилийн байдлаар өмнөх оны үнэлгээнээс 0.57%-р ахиулсан | |
| 5 | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр улирал бүр дүгнэлт хийж, тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд дүгнэлт хийж ажиллах | Хэрэгжилтийн хувь | 89 | 50 | 90 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа хэрхэн хэрэгжиж байгааг хяналтдаа авах зорилгоор долоо хоног бүрийн 1 дэх өдрийн 9:30 минутаас албан хаагчдын дунд шуурхай хурал зохион байгуулж гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжилт ямар шатанд явж байгааг хяналтдаа авч албан хаагчдад хэрхэн үйл ажиллагааг зохион байгуулах талаарх арга зүйн дэмжлэг үзүүлж байна. Төрийн албан хаагчийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангуулах явцын ярилцлагыг зохион байгуулж журмын дагуу баталгаажуууллаа. 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө хэрэгжилт 11 дүгээр сарын байдлаар /хүрэх түвшин/ 91.5 хувьд хүрээд байна.<br>Үр дүн:<br>✓ Байгууллагын хэмжээнд гарсан бүх төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар 7 хоног бүрийн нэг дэх өдөр хамт олноороо хэлэлцэж удаашралтай байгаа заалтыг эрчимжүүлэх ажиллагаа тогтмол хийж хэрэгжүүлж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажилладаг болсон. | |
| Нийт дүн: | | | | | | | | 100 |

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР